

БАТЛАВ

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ



Л.ДОРЖСҮРЭН



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР”
БОЛОН “ЗАГИЙН УСНЫ ХООЛОЙН ГҮНИЙ УСНЫ ОРДООС
НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ХҮРТЭЛ УС ТАТАХ ШУГАМ
ХООЛОЙ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

ХЯНАСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УСНЫ
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

М.АНУДАРЬ

2025 он

АГУУЛГА

1. ОРШИЛ.....	1
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2.1 Төслийн зорилго, хүчин чадал.....	2
2.1.1 “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн төсөл.....	2
2.1.2 “Загийн усны хоолойн гүний усны ордоос нүүрс баяжуулах үйлдвэр хүртэл ус татах шугам хоолой” төсөл	3
2.2 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий төлөвлөлт.....	4
2.3 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл.....	5
3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
3.1 Уур амьсгал.....	6
3.2 Геоморфологи	6
3.3 Хөрс.....	6
3.4 Ургамлан бүрхэвч.....	6
3.5 Нийгэм, эдийн засаг	7
3.6 Төслийн талбайн байршил.....	7
3.6.1 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл.....	7
3.6.2 “Загийн усны хоолойн гүний усны ордоос нүүрс баяжуулах үйлдвэр хүртэл ус татах шугам хоолой” төсөл	8
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .	9
4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц	9
4.2 Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ.....	11
4.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
11. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал	2
Хүснэгт № 3. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл	5
Хүснэгт № 4. 2024 оны хүн амын тоо	7
Хүснэгт № 5. 2024 оны мал тоо /мян.тол/	7
Хүснэгт № 6. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн талбайн хэмжээ	8
Хүснэгт № 7. Эрсдэлийн үнэлгээний матриц.....	9
Хүснэгт № 8. Магадлалын үнэлгээний шалгуур	9
Хүснэгт № 9. Үр дагаварын үнэлгээний шалгуур.....	9
Хүснэгт № 10. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт	10
Хүснэгт № 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүснэгт	14
Хүснэгт № 12. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөний хүснэгт	19
Хүснэгт № 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүснэгт	20
Хүснэгт № 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүснэгт	24
Хүснэгт № 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний хүснэгт	25
Хүснэгт № 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардалын хүснэгт.....	28
Хүснэгт № 17. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	29
Хүснэгт № 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	30

1. ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол, 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газраас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлагдсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/455 дугаар тушаалаар байгуулагдсан “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тус тус тулгуурлан Тавантолгойн ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулж шинэ, дэвшилтэт болон өндөр технологи, дамжуулах, нутагшуулах болон нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлээд зогсохгүй уул уурхай, зам тээвэр, усан хангамж, байгаль орчин зэрэг олон салбарыг хамарсан цогц бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна

Тус хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн эхний үе шат болох жилд 10 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэрийг 2024 оны 06 дугаар сард ашиглалтад оруулж олон улсын стандартын шаардлагад нийцсэн хоёр төрлийн баяжмалыг үйлдвэрлэж эхлээд байна.

Баяжуулах үйлдвэрийн үндсэн бүтээгдэхүүн буюу коксжих нүүрсний чанарын хувьд үнслэг нь 10.5-аас доош, барьцалдах чадвар нь 80-аас дээш 7000-аас дээш илчлэгтэй коксжих чанарын нүүрс гарч байгаа бол эрчим хүчний нүүрсний чанарын хувьд үнслэг 22-оос доош, 6000-аас дээш илчлэгтэй, 23-аас доош дэгдэмхийтэй, хүхрийн агууламж 1-ээс доош үзүүлэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Баяжуулах үйлдвэрт Австрали улсын McLanachan брэндийн бутлуур, Aury брэндийн усгүйжүүлэх центрифуги, шигшүүр, Eriez брэндийн соронзон сепаратор, Haiwang брэндийн шламгүйжүүлэх циклон, хүнд орчны циклон, нягтаар тунаах машин, SGB брэндийн насос гэх мэт дэлхийд тэргүүлэгч тоног төхөөрөмжийг суурилуулсан. Технологийн хувьд 2 шатны хүнд орчны циклон, нягтаар тунаах машин TBS, хөвүүлэн баяжуулалт флотмашин, усгүйжүүлэх төхөөрөмж центрифуги, фильтр пресс зэрэг дэлхийн жишигт нийцсэн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдийг сонгон суурилуулсан бөгөөд технологийн хувьд 5-р үеийн шинэ үйлдвэр гэдгээрээ онцлогтой.

Үйлдвэрийн нэгдсэн удирдлагын төвөөс 1100 гаруй тоног төхөөрөмжийг 24 цагийн хугацаанд хянаж, асаах, унтраах, процессын тохиргоо хийж 250 камераар үйлдвэрлэлийн процессыг бүрэн хянах боломжтой автомат үйлдвэр юм.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Нүүрс баяжуулах үйлдвэр” –ийн батлагдсан ТЭЗҮ-ийн хүрээнд БОАЖЯ-ны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 13/1034 дугаартай ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулсан.

БОННУ-ний ажлын үр дүнд үйлдвэрийн барилга байгууламж барих үеийн болон үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны үе дэх байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн зорилго, хүчин чадал

2.1.1 “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн төсөл

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр”-ийн төсөл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр (цаашид НБҮ гэх) нь тасралтгүй ажиллагаатайгаар долоо хоногийн 7 өдөр 12 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд баяжуулах үйлдвэр нь 7 хоногт 1 удаа төлөвлөгөөт зогсолт хийж, засвар үйлчилгээ явуулахаар төлөвлөсөн. НБҮ-ийг 2024 оны 6-р сараас ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилд 5.0 сая тонн, 2024-2025 онд 10.0 сая тонн нүүрс баяжуулна. 2026 оноос баяжуулах үйлдвэрийн 2 ба 3 дахь шугам ашиглалтад орсноор үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахаар төлөвлөөд байна. НБҮ-ийн ажиллах горим, хүчин чадлыг тооцон Хүснэгт 1-д үзүүлэв.

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн ерөнхий гүйцэтгэгчээр “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК сонгогдон ажиллаж байна.

Хүснэгт № 1. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал

Үйл ажиллагааны хуваарь	Нэгж	Ашиглалтын жил			
		1	2	3	4
Жилийн календарь хоног	Хоног	183	365	365	365
Өдрийн хуанлийн цаг	Цаг	24	24	24	24

Жилийн хуанлийн цаг	Цаг	4,368	8,760	8,760	8,760
Засвар үйлчилгээний хоног /7 хоногт 1 удаа/	Хоног	26	52	52	52
Жилд бүрэн ажиллах хоног	Хоног	157	313	313	313
Жилд ажиллах боломжит цаг	Цаг	3,768	7,512	7,512	7,512
Цаг ашиглалтын коэффициент	%	0.9	0.9	0.9	0.9
Хоногт ажиллах бодит цаг	Цаг	21.6	21.6	21.6	21.6
Техникийн бэлэн байдлын коэф.	-	0.888	0.888	0.888	0.888
Жилд ажиллах бодит цаг	-	3,011	6,003	6,003	6,003
Үйлдвэрийн хүчин чадал					
Цагийн хүчин чадал /Ad/	т/цаг	1,661	1,661	1,661	5,000
Цагийн хүчин чадал /Ar/	т/цаг	1,794	1,800	1,800	5,400
Хоногийн хүчин чадал	т/хоног	38,753	38,877	38,877	116,631
Жилийн хүчин чадал	т/жил	5,000,000	10,000,000	10,000,000	30,000,000

2.1.2 “Загийн усны хоолойн гүний усны ордоос нүүрс баяжуулах үйлдвэр хүртэл ус татах шугам хоолой” төсөл

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд энэ тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Уг тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая.тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая.тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Загийн усны хоолойн газрын доорхи усыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр хүртэлх ус хангамжийн систем нь дараах барилга байгууламжаас бүрдэнэ:

- Гүний худаг;
- Ус цуглуулах шугам;
- Ус цуглуулах усан сан;

- Өргөлтийн насос станц;
- Ус дамжуулах гол шугам;
- 2х1500 м³ усан сан;
- Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд;
- 2х1500 м³ усан сангаас Нүүрс баяжуулах үйлдвэр хүртэлх салбар шугамууд

Тавантолгойн коксжих нүүрсний ордыг түшиглэн барихаар төлөвлөж буй нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийг Загийн усны хоолойн (I, II дэд) хэсэгт илрүүлэн тогтоож, усны ашиглалтын нөөц баялгийг үйлдвэрлэлийн С зэргээр (63.65 л/с)-ээр тооцсон бөгөөд тус ус дамжуулах шугамаар 5,499.31 м³/хоног ус дамжуулахаар төлөвлөсөн. Тавантолгойн нүүрсний уурхайн ус хангамжийн систем нь нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн шаардлагын улмаас 24 цаг тасралтгүй ажиллагаатай байна. Энэ байгууламж нь БНБД 40-02-16-д заасны дагуу ус хангамжийн I зэрэглэлд хамаарах учир 2 ажлын насостай байхад нөөц насос 1-ийг байрлуулах шаардлага тавигдаж байна. Иймд 1 нөөц насостой буюу нийт 3 насос суурилуулахаар техникийн ерөнхий шийдэл гаргав. Насосууд нь өөр дээрээ болон удирдлагын самбарт тусдаа давтамж хувиргагчаар тоногловол байвал цахилгаан эрчим хүчинд хэмнэлттэй байна.

Гүний худгуудын бүлэглэлт Загийн усны хоолойн I, II дэд хэсэгт байрлах нийт 14 ширхэг гүний худаг байгуулна. Гүний худгийн барилгын эргэн тойронд “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-д заасны дагуу энгийн болон онцгой хамгаалалтын бүс тогтоон заасан зайд хамгаалалтын хашаа төлөвлөнө. Хамгаалалтын төмөр хашаа нь гүний худгийн цооногийн координатаас 50 м-ийн зайд байна.

Өргөлтийн насос станцууд, шугам хоолойн хоорондын ажиллагааны гидравлик нөхцөлийг тогтвортой, найдвартай байлгах үүднээс насос станц бүрийн сорох талд усан сан төлөвлөнө. Усан сангийн хийц, материалыг хүйтэн бүсийн онцлог, технологийн шаардлагын үүднээс шийднэ. ӨНС-1-ийн өмнө 1х500м³ эзэлхүүнтэй, ӨНС-2-ын өмнө 1х500м³ эзэлхүүнтэй 12 м диаметр дугуй хэлбэртэй, өндөр нь 5.4 м газар доорх усан сан байрлана.

Ус нөөцлөх усан сан нь ус дамжуулах гол шугамын төгсгөлд системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зориулалттайгаар байгуулагдана. Ус хангамжийн системийн ус дамжуулах хоолойд осол гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн технологийн шаардлагын дагуу технологийн усыг бууруулахгүйгээр хангана.

“Загийн усны хоолой”-н гүний худгуудаас усыг салбар шугам хоолойгоор цуглуулах усан санд нэгтгэн авч өргөлтийн насос станцуудын тусламжтайгаар далд шугам хоолойгоор шахаж уурхайн ойролцоо байрлах усан санд хүргэнэ. Уг усан сангаас уурхайн ус хэрэглээ болон кемп, захиргааны барилга, унд ахуйн усны хэрэглээгээ авах юм.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн Загийн усны хоолойн ус хангамжийн төслийн тус бүр 55 кВт хүчин чадалтай 2 өргөх насос станцыг тэжээх 2 ширхэг трансформаторын 35 кВт тал дээр SEL брэндийн SEL-311L шугамын гүйдлийн дифференциал хамгаалалтыг суурилуулна. Цогтцэций сумаас Манлай сум руу явсан 35кВ-ын ЦДАШ-наас огтолгоо хийж дэд өртөө байгуулахад 12 км урттай 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаар төлөвлөсөн байна. Тус төслийн 35 кВт-ын ЦДАШ-д ЗТБ.35-04.18а маркийн төмөр бетон хийцтэй тулгуурыг суурилуулахаар сонгожээ.

2.2 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий төлөвлөлт

Тус үйлдвэрийг хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нэгдүгээр үе шатанд 10 сая тонн хүчин чадалтай эхний үйлдвэр, хоёрдугаар шатанд 20 сая тонн хүчин чадалтай үлдсэн 2 үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах ба тус бүр нь 10 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий 3 үйлдвэрийг байгуулна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь 2323173, 2323174 нэгж талбарын дугаартай газарт нийтдээ 129,37 га талбайг хамарна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь дараах байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрс хадгалах байгууламж:

- Бүтээгдэхүүн хадгалах байгууламж:
- Нүүрс бутлах, шигшиж ангилах байгууламж:
- Нүүрс угаах байгууламж:
- Бүтээгдэхүүн, хаягдал усгуйжүүлэх байгууламж:
- Бүтээгдэхүүний хаягдал хадгалах байгууламж:
- Эргэлтийн усан сан:
- Цэвэр усан сан:
- Хаягдлын овоолгын талбай:
- Технологийн зам талбай:
- Авто машинд нүүрс ачих байгууламж:
- Вагонд нүүрс ачих байгууламж:
- Уурын зуух:
- Автожингийн байр:
- Бохир хуримтлуулах байр:
- Хог хаягдлын цэг:
- Туслан гүйцэтгэгч компаниудын барилга, байгууламж:
- Химийн бодис, шатах туслах материалын цэг:

➤ Аж ахуйн хэсгээс бүрдэнэ.

Зураг № 1.
“Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий төлөвлөлт



2.3 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт № 2. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
“Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК	Үндсэн гүйцэтгэгч	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Хаан тауэр 23 давхар 2303 тоот
“Баяас Прайм Инженеринг” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	УБ, ХУД 18-р хороо, Академи сентер, 3 давхар
“Билгүүн Монгол Констракшн” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо, 876 тоот
“Дулаан Баян Говь” ХХК	Бетон зуурмагийн үйлдвэр	Өмнөговь аймаг, Даланзадгад, 3-р баг Далан, Говь Сэндс төв 306 тоот

3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3°C хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0°C .

Жилийн дундаж агаарын температур нь 0.9°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1°C байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна. Салхины зонхилох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

3.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

3.3 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

3.4 Ургамлан бүрхэвч

“Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марзтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамал бүрхэвч нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас

шалтгаалан таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдэлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

3.5 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2024 оны байдлаар нийт 79211 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 9658 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол Улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

Хүснэгт № 3. 2024 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	79211	9658
Эрэгтэй	39770	4722
Эмэгтэй	39441	4936
Өрхийн тоо	25346	2859

Өмнөговь аймаг нь 2024 оны байдлаар 15 сумын 59 багт 1.9 сая толгой мал тоологдсоноос Цогтцэций суманд 134.87 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт № 4. 2024 оны мал тоо /мян.тол/

Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	1970.1	84.9	25.2	148.2	541.5	1170.3
Цогтцэций	134.8	9.5	2.1	3	47.2	73.0

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 30 орчим туслан гүйцэтгэгч, гэрээт, ханган нийлүүлэгч компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.


Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгой бүлэг ордын үйл ажиллагаа жилээс жилд цар хүрээгээ тэлж олборлолт экспортын хэмжээ нэмэгдэж Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй татвар, хураамжийн хэмжээ өсөн нэмэгдэж Улсын эдийн засгийн хөгжилд оруулж хувь нэмэр оруулан ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны ашгаас уурхай дагасан томоохон бүтээн байгуулалт – мега төслүүд болох Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр зам, 30 сая тонныг хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн төслийг санхүүжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын иргэн бүрд ногдол хувьцааны ноогдол ашгийг олгон ажиллаж байна

3.6 Төслийн талбайн байршил

3.6.1 “Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл

Төслийн талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос 540 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн өмнө зүгт 7 км зайд байрлана.




Зураг № 2. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн байршлийн зураг

Хүснэгт № 5. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн талбайн хэмжээ

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, га
1	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Сийрст баг	129,37

3.6.2 “Загийн усны хоолойн гүний усны ордоос нүүрс баяжуулах үйлдвэр хүртэл ус татах шугам хоолой” төсөл

“Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НБҮ хүртэл ус татах шугам хоолой” төсөл нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 425 км, аймгийн төв Даланзадгадаас зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн хойш зүгт 65 км хүртэл зайд эхлэлийн цэг орших ба эхлэлийн цэгээс шулуунаар үргэлжлэн сумын төвөөс зүүн ба зүүн урагш 6 км зайд байрлах нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд хүрнэ.



Зураг № 3. "Загийн усны хоолой" төслийн байршлийн зураг

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлгийн зорилго нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар “Хатандалай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Тавантолгойн Ордыг Түшиглэн Байгуулагдах “Үйлдвэр Технологийн Парк” -ийн хүрээнд хэрэгжих “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” -ийн Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний Тайлан (цаашид БОННУ гэх) -д тусгасан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг баримталлаа. БОННУ-д төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг их нөлөөлөл 11.6%, дунд зэргийн нөлөөлөл 23.5%, бага нөлөөлөл 31.5%, нөлөөлөлгүй 33.4% гэж үнэлсэн ба дунджаар орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд дунд зэргийн нөлөөлөл үзүүлнэ гэж дүгнэжээ. Хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсэг нь агаар болон хөрсөн бүрхэвч юм.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт № 6. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 7. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 8. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана

V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана
---	--------	---	----------------	---

Хүснэгт № 9. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Марадлал	Үр дагавар	Эрсдэлийн зэрэглэл	Хариу арга хэмжээ
1	2	3	4	5	6	7
1. “Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл						
Ажилчдын хотхон	Дулаан түгээх	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих
			4	1	II	Түлш зарцуулалтын хяналт
	Их хэмжээний хог хаягдал	Ландфилийн талбай нэмэгдэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
Барилга шинээр байгуулах	Газар шорооны ажил	Тоосжилт	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ
		Хөрсний эвдрэл	4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт
			4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт
Засвар, угсралт эрхлэх	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт
			4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
			4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг
	Бохирлогдсон материал хаягдах		4	3	III	Аюултай бодисын удирдлага
			4	3	III	Хөрсний бохирдлын хяналт
	Тос, шинэгн материал хаягдана		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
			4	4	IV	Хөрсний бохирдлын хяналт
	Химийн бодисийн алдагдал		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө
			4	4	IV	Аюултай бодисын хяналт, бүртгэл
			4	4	IV	Ажлын байрны эмх цэгц
2. “Загийн усны хоолой” төсөл						
Кемп, барилгын ажил	Хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол	4	1	II	Хог хаягдлын ангилан ялгалт
			3	1	I	Хогийн түр цэг байгуулах.

						ариутгал халдваргүйжүүлэлт
			3	2	II	Гэрээ байгуулах, хатуу хог хаягдлыг зөвшөөрөлтэй цэгт зайлуулах
			3	2	II	Бохир усыг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх
Машин техникнийн хөдөлгөөн	Бэлчээрийн доройтол, салаа зам	Хөрсний эвдрэл	4	3	III	Зам талбайг усаар чийглэх
			4	3	III	Хөдөлгөөний хурдын хязгаарлалт, маршрутын замаар зорчуулах
			4	3	III	Нөлөөллийн бүсийн айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, ажлын байраар хангах, техникийн дэмжлэг үзүүлэх
	Дуу чимээний түвшин нэмэгдэх	Амьдрах орчин	4	3	III	
Ус хангамж /ахуй/	Ус ашиглах	Усны эх үүсвэр багасна	4	2	II	Усны хэрэглээний хяналт
Ус хангамж /барилга/			4	3	III	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр гэх мэт
Барилга байгууламж, шугам хоолой	Зөвшөөрөлгүй ашиглах	ТТАМ нөөц, хууль зөрчих	4	4	V	Зөвшөөрөлтэй ААН-тэй гэрээ байгуулж ашиглах
	Нүх, ухаш үүсэх	Мал амьтан унах	3	2	III	ХАБ-н арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх
Ажилчдын кемп	Зөвшөөрөлгүй ашиглах	Хөрс, газрын гадарга доройтох	4	3	IV	Орон нутгаас түр ашиглах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах

4.2 Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ

Газрын гадарга, хэвлий

